



# СЭЛЭНГЭ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



## ХҮН АМЫН АМЬДАРЧ БУЙ ОРЧИН, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ



2018 он

## Гарчиг

I.	Аймгийн товч танилцуулга.....	3
II.	Орон сууцны нөхцөл.....	4
III.	Ахуйн нөхцөл.....	5
IV.	Суралцах нөхцөл.....	6
V.	Эрүүл амьдрах орчин.....	7 - 8
VI.	Аюулгүйн байдал.....	9
VII.	Хүүхэд ба гэр бүл.....	10

## **I. Аймгийн товч танилцуулга**

Сэлэнгэ аймаг маань Монгол орны нутгийн хойд хэсэгт Орхон Сэлэнгийн сав газрын дунд зэргийн уулс бүхий 41,2 мянган дөрвөлжин км нутаг дэвсгэр эзлэн оршдог 17 сум 56 баг, тосгоны статустай 6 багтай аймаг юм. Аймгийн төв нь Сүхбаатар хот, нийслэл Улаанбаатар хоттой төмөр зам болон асфальтан хучилттай замаар холбогддог ба нийслэлээс 321 км зайтай оршино. 1931 онд "Газар тариалангийн аймаг" нэртэйгээр байгуулагдаж, 1934 онд ард түмний Хүсэлтээр Сэлэнгэ аймаг хэмээн нэрлэжээ.

Сэлэнгэчүүдийн хөдөлмөрөөр бий болсон эх орны "Орхон" сортын улаан буудай, Шаамарын алим, нарийн нарийвтар ноост "Орхон", "Хангай", "Ерөө" үүлдрийн хонь, махны "Сэлэнгэ" үүлдрийн үхэр зэрэг нь энэ нутгийнхны бахархал болно.

Сэлэнгэ аймаг нь газар тариалан голлон хөгжүүлсэн аймаг юм. Манай орны газар тариалангийн талбай нь үлэмж хэсэг Орхон Сэлэнгийн сав газарт төвлөрсөн байдаг. Улсын үр тарианы 45.0 орчим хувийг үйлдвэрлэдэг, 570 гаруй мянган малтай. Сэлэнгэ аймагт мод боловсруулах, гурилын, хүнсний, спирт бал бурмын үйлдвэр, вагон засварын газрууд байдаг. Сүхбаатар хот төмөр зам ба авто замын гол зангилаа нутаг бөгөөд хилийн байнгын чухал гарцын нэг юм.

Аймгийн нутгийн баруун хойд хэсгээр юрийн хурдас, өмнөд хэсгээр нь герциний боржин, зүүн хэсэгт гүний боржин тархжээ. Аймгийн нутагт Улаантолгой, Шарын голын нүүрс, Төмөртэй, Төмөртолгойн төмөр, Их алтат, Бугант, Толгойтын алт болон барилгын хэрэглэгдэхүүн элбэгтэй.

Сэлэнгэ, Орхон, Хараа, Ерөө зэрэг Монгол орны томоохон гол мөрнүүд урсдаг. Ерөөгийн, Товхонханы, Хондын, Могойн зэрэг рашаануудтай ба нутгийн ихэнхи хэсэгт уулын хар шороон хөрс, гол мөрний хөндийн хагшаа хурдаст хөрс тархжээ.

Хүн ам нь 2017 оны жилийн эцсийн тооллогын дүнгээр суурин хүн амын тоо 108768-д хүрсэн нь өмнөх оноос 1.96 хувиар нэмэгдсэн байна. Хүн амын нас хүйсийн бүтцээр авч үзвэл нийт хүн амд эрэгтэйчүүдийн эзлэх хувь 50.6, эмэгтэйчүүдийн эзлэх хувь 49.4, 0-14 насны хүүхэд 29.1, 15-59 насны хүн 63.9, 60-аас дээш насны хүмүүс 7.0 хувийг эзэлж байна.

Хүн амын нягтралын хувьд 1км.квадрат дөрвөлжин талбайд 2.6 хүн ногддог нягтаршил ихтэй аймаг юмаа.

## II. ОРОН СУУЦНЫ НӨХЦӨЛ

Үзүүлэлт	2016		2017	
	Тоо	Нийт өрхөд эзлэх хувь	Тоо	Нийт өрхөд эзлэх хувь
<b>1. Аймгийн нийт өрхийн тоо</b>	29521	100,0	29912	100,0
<b>2. Байршил: Аймгийн төв, Хот тосгонд</b>	15402	52,2	10251	34,3
<i>Сумын төв, Хөдөөд</i>	14119	47,8	19661	65,7
<b>3. Сууцны төрлөөр: Гэрт</b>	7356	24,9	7495	25,1
<i>Байшинд</i>	22165	75,1	22417	74,9
<b>4. Сууцны нөхцөл: Бие даасан Тохилог сууцанд</b>	385	1,3	387	1,3
<i>Орон сууцны байшинд</i>	3969	13,4	4021	13,4
<i>Сууцны тусдаа байшинд</i>	16683	56,5	16870	56,4
<i>Гэр сууцанд</i>	7356	24,9	7495	25,1
<i>Нийтийн байранд</i>	659	2,2	665	2,2
<i>Бусад сууцанд</i>	469	1,6	474	1,6

2017 оны жилийн эцсийн байдлаар өрхийн тоо өмнөх оноос 1.3 хувиар өсч 29912 болсон байна. Байршлийн хувьд нийт өрхийн 34.3 нь аймгийн төв, хот тосгонд, 65.7 хувь нь сумын төв, хөдөөд амьдарч байна. Сууцны төрлөөр авч үзвэл 74.9 хувь нь байшинд, 25.1 хувь нь гэрт амьдарч байгаа бол сууцны нөхцөлөөр харвал 1.3 хувь нь бие даасан тохилог сууцанд, 13.4 хувь нь орон сууцны байшинд, 56.4 хувь нь сууцны тусдаа байшинд, 25.1 хувь нь гэр сууцанд, 2.2 хувь нь нийтийн байранд амьдарч байна.


### III. Ахуйн нөхцөл

Үзүүлэлт	2016		2017	
	Тоо	Нийт өрхөд эзлэх хувь	Тоо	Нийт өрхөд эзлэх хувь
<b>1. Аймгийн нийт өрхийн тоо</b>	29521	100,0	29912	100,0
<b>5.Халаалтын төрлөөр: Төвлөрсөн систем</b>	5106	17,3	5164	17,3
Нам даралтын зуух	410	1,4	418	1,4
Цахилгаан халаагуур	82	0,3	80	0,3
Ердийн галлагаа	23923	81,0	24250	81,1
<b>6. Цахилгаан хангамж: Төвлөрсөн систем</b>	24871	84,2	25143	84,1
Бусад эх үүсвэр	4532	15,4	4629	15,5
цахилгааны эх үүсвэргүй	118	0,4	140	0,5
<b>7. Усан хангамж: Төвлөрсөн усан хангамж</b>	4836	16,4	4907	16,4
Бие даасан систем	695	2,4	702	2,3
Зөөврийн	23990	81,3	24303	81,2
<b>8. Хатуу хог хаягдал: Үйлчилгээий байгууллагаар</b>	12790	43,3	13017	43,5
Зөвшөөрөгдсөн цэгт	11605	39,3	11636	38,9
Тогтсон цэг байхгүй	5126	17,4	5259	17,6
<b>9.Бохир ус зайлуулалт: Төвлөрсөн систем</b>	4473	15,2	4528	15,1
Бие даасан систем	210	0,7	212	0,7
Бусад	24838	84,1	25172	84,2

2017 оны жилийн эцсийн байдлаар халаалтын төрлөөр 17.3 хувь нь төвлөрсөн системд холбогдсон байгаа бол цахилгаан хангамжийн хувьд 84.1 хувь нь төвлөрсөн системд, төвлөрсөн усан хангамжанд 16.4 хувь нь холбогдсон байна.

#### IV. Суралцах нөхцөл

	2014 / 2015	2015 / 2016	2016 / 2017	2017 / 2018
<b>Сургуулийн бүлгийн тоо</b>	687	713	715	722
<b>Үндсэн багшийн тоо</b>	983	1035	839	1024
<b>Нийт сурагчдын тоо</b>	17580	18413	18787	18937
<b>Дотуур байранд амьдарч буй хүүхдийн тоо</b>	1165	1220	1189	1191
<b>1-р ангид элсэгчид</b>	2139	2236	2127	2157
<b>10-р ангид элсэгчдийн тоо</b>	1562	1477	369	1033



2017 онд 35 сургуульд 18807 сурагчид суралцаж байгаа ба 1036 үндсэн багш ажиллаж байна. Хичээлийн шинэ жилд 2139 хүүхэд шинээр 1 дүгээр ангид элсэн орж, албан бус сургалтанд нийт 519 сурагч суралцаж байна.

## V. Эрүүл амьдрах орчин

### 5.1. Эрүүл мэндийн үзүүлэлт

Үзүүлэлт	2014 - XII	2015 - XII	2016 - XII	2017 - XII
Эмнэлэгийн тоо	94	94	84	95
Их эмч	189	209	235	235
Эм зүйч	15	18	24	27
Тусгай мэргэжлийн мэргэжилтэн	534	535	555	607
Бусад ажилтан	441	434	436	371
Эмнэлэгийн орны тоо	621	621	708	708
Стационарт эмчлэгдсэн хүний тоо	15953	14623	23483	22683

### 5.2. ТӨРСӨН ЭХ, боловсролын түвшнээр

үзүүлэлт	2014 -XII	2015 - XII	2016 - XII	2017 - XII
<b>Бүгд</b>	<b>2024</b>	<b>1945</b>	<b>1826</b>	<b>1712</b>
-дээд боловсрол	417	414	360	409
-мэргэжлийн болон техникийн боловсрол	82	93	78	84
-дунд боловсрол	1464	1331	1260	1108
-бага боловсрол	44	74	101	91
-боловсролгүй	17	33	27	20

### 5.3. ТӨРСӨН ЭХ, насны бүлгээр

Үзүүлэлт	2014 -XII	2015 - XII	2016 - XII	2017 - XII
<b>Бүгд</b>	<b>2024</b>	<b>1945</b>	<b>1826</b>	<b>1712</b>
20 хүртэлх	150	232	116	110
20 - 24	598	486	500	419
25 - 29	542	557	555	539
30 - 34	428	393	359	378
35 - 39	251	231	238	221
40 - 44	52	43	57	45
45 - 49	3	3	1	


#### 5.4.НАС БАРАЛТ, насны бүлгээр

Үзүүлэлт	2014 -XII	2015 - XII	2016 - XII	2017 - XII
<b>Бүгд</b>	<b>485</b>	<b>527</b>	<b>570</b>	<b>494</b>
<b>үүнээс эмэгтэй</b>	202	236	222	197
<b>0 - 1</b>	13	16	27	19
<b>1 - 5</b>	5	7	9	8
<b>6 - 18</b>	13	17	14	7
<b>19 - 54</b>	159	183	182	163
<b>54 дээш</b>	295	304	338	297

2017 онд аймгийн хэмжээгээр нийт 1712 эх төрж, 1720 хүүхэд мэндэлсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс төрөлт 6.2 хувиар буурчээ. Нас барсан хүний тоо 494 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 76 хүнээр буюу 13.3 хувиар буурсан байна. 0-1 хүртлэх хүүхдийн эндэгдэл 19, 1-5 хүртлэх насны хүүхдийн эндэгдэл 7 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна. Нийт нас баралтын шалтгааны 13.1 хувь нь осол гэмтлийн, 24.8 хувь нь хорт хавдрын өвчний шалтгаантай байна.

2017 оны жилийн эцсийн байдлаар 95 эмнэлэг үйл ажиллагаа явуулж, 235 эмч, 27 эмзүич ажиллаж байна.

#### Төрсөн эх, амьд төрсөн хүүхэд, сүүлийн 4 жилээр





## VI. Аюулгүйн байдал

2017 оны байдлаар нийт 729 гэмт хэрэг бүртгэгдсэний 230 нь согтуугаар үйлдэгдсэн ба гэмт хэргийн тоо өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 9.0 хувиар өсч гэмт хэргийн илрүүлэлт 67.3 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 12.5 хувиар буурсан байна. Өмөнх оны мөн үеэс Ерөө, Мандал, Сайхан, Хүдэр, Сүхбаатар сумдад гэмт хэрэг 6-37 гаралтаар өссөн байна.

### 6.1. Гэмт хэрэг

Сумын нэр	Гэмт хэргийн тоо, төрлөөр					Бусад
	Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг г/х	Нийгмийн аюулгүй байдлын эсрэг г/х	Өмчлөх эрхийн эсрэг г/х	үүнээс малын хулгай	Тээврийн хэрэгслийн хөд-ний аюулгүй байдлын эсрэг г/х	
<b>ДҮН</b>	<b>264</b>	<b>50</b>	<b>178</b>	<b>42</b>	<b>99</b>	<b>138</b>
Алтанбулаг	15	2	4	1	5	20
Ерөө	24	0	5	2	10	21
Зүүнбүрэн	7	0	4	1	2	1
Мандал	87	17	72	7	15	28
Орхон	6	0	6	5	5	6
Сант	5	1	2	0	2	1
Цагааннуур	6	2	3	1	0	1
Баянгол	12	2	9	4	19	10
Сайхан	15	4	21	7	14	8
Орхонтуул	8	0	7	4	0	0
Баруунбүрэн	4	0	4	2	5	3
Шаамар	6	1	3	1	6	2
Хүдэр	10	2	2	0	3	15
Сүхбаатар	50	17	27	2	8	20
Жавхлант	2	1	3	2	2	1
Түшиг	4	1	3	0	2	1
Хушаат	3	0	3	3	1	0

Бүртгэгдсэн гэмт хэргийн 24.4 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 36.2 хувийг хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 6.8 хувийг нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 13.6 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний

аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 19.0 хувийг бусад төрлийн гэмт хэрэг эзэлж байна. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн 23.6 хувийг малын хулгай эзэлж байна.

## VII. Хүүхэд ба гэр бүл

<b>Хөгжлийн бэрхшээлтэй иргэн</b>	<b>4758</b>
<b>Хагас өнчин хүүхдийн тоо</b>	1456
<b>Бүтэн өнчин хүүхдийн тоо</b>	143
<b>Өрх толгойлсон хүний тоо</b>	4112
<b>Ихэр хүүхэдтэй өрхийн тоо</b>	253
<b>Ганц бие өндөр настай өрхийн тоо</b>	1296
<b>Үрчлэгдсэн хүүхдийн тоо</b>	57
<b>Гэрлэлтийн тоо</b>	566
<b>Цуцлалтын тоо</b>	141

2017 оны жилийн эцсийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэн 4758, хагас өнчин хүүхдийн тоо 1456, бүтэн өнчин хүүхдийн тоо 143, өрх толгойлсон хүний тоо 4112, ихэр хүүхэдтэй өрхийн тоо 253, Үрчлэгдсэн хүүхдийн тоо 57 бүртгэгдсэн байна. Мөн он гарснаар 566 хос гэрлэлтээ бүртгүүлж, 141 хос гэрлэлтээ цуцлуулсан байна.

Судалгаа гаргасан:

Ч.Цэнд-Аюуш /Ахлах мэргэжилтэн

Хянасан:

Д.Гүндэгмаа /Хэлтсийн дарга/

Сэлэнгэ аймгийн Статистикийн хэлтэс